




2024 JUL

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ АЛБА

ДНБ-ИЙ ӨСӨЛТ 2024 ОНЫ 2-Р УЛИРАЛД 5.6% БАЙГАА НЬ 1-Р УЛИРЛЫНХААС (7.8%) БУУРСАН ҮЗҮҮЛЭЛТТЭЙ БАЙНА.

- Монгол Улсын ДНБ-ий өсөлт энэ оны 2-р улиралд 5.6 хувь байсан нь өмнөх улирлаас 2.2 хувиар буурсан үзүүлэлт юм. Өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрч, малын хорогдол эрс нэмэгдсэний улмаас хөдөө аж ахуйн салбар 3.9 хувиар буурсан.
- 7 дугаар сард инфляцын түвшин 5.5 хувь хүрч, өмнөх сарынхаас 0.4 хувиар буюу бага зэрэг өссөн байна. Инфляцын өсөлтийн 30.6 хувь нь хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс шалтгаалжээ.
- Засгийн газар төсвийн зардлыг 3.1 их наяд төгрөгөөр нэмэгдүүлж баталлаа. Нэмэгдсэн төсвийн 1.8 их наяд нь төсөл хөтөлбөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын зардал байгаа бол 1.2 их наяд нь урсгал зардал байна.
- Инфляцын түвшин оны эхэн үеэс зорилтот түвшин +/-6 хувьд хүрсэн тул бодлогын хүүг 11 хувь хэвээр үлдээсэн.
- Америк долларын эсрэг төгрөгийн ханш сүүлийн гурван сарын хугацаанд тогтвортой байсан ба ханш 5 дугаар сард 3,381.2 төгрөг байсан бол 7 дугаар сард 3,380.9 төгрөг байлаа.

НИЙТ ЭКСПОРТОЛСОН НҮҮРСНИЙ БИЕТ ХЭМЖЭЭ 35.5 ХУВИАР ӨССӨН Ч НҮҮРСНИЙ ХИЛИЙН ДУНДАЖ ҮНЭ ӨМНӨХ ОНЫХООС 7.3 ХУВИАР БУУРСАН БАЙНА.

- Улс төрийн сонгуультай холбоотойгоор импорт өмнөх оныхоос 28 хувиар, хэрэглээний бүтээгдэхүүн 52 хувиар, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн 35 тус тус хувиар өссөн.
- Автомашины импортын тоо хэмжээ эхний 7 сард 68,551 хүрч өмнөх оны мөн үеэс 78 хувиар өссөн байна. Харин дизель, түлш шатахууны импорт 18 хувиар өсжээ.
- Экспортолсон нийт нүүрсний биет хэмжээ 35.5 хувиар өсөж, 46 сая тоннд хүрч, нийт экспортын орлогын 58 хувийг бүрдүүлсэн. Хэдийгээр биет хэмжээ өссөн ч нүүрсний хилийн дундаж үнэ өмнөх оны мөн үеэс 7.3 хувиар буурч, үүнийг дагаад гадаад худалдааны тэнцэл 22.3 хувиар буурч, 2.8 тэрбум ам.доллар болсон.

НИЙТ ӨРХИЙН 62.3 ХУВЬ НЬ ӨР, ЗЭЭЛТЭЙ АМЬДАРЧ БАЙГАА БА ИРГЭД САРД ДУНДЖААР 1.1 САЯ ТӨГРӨГИЙГ ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТӨД ТӨЛЖ БАЙНА.

- Нийт өрхийн 62.3 хувь нь зээлтэй байгаа бөгөөд 2024 оны эхний хагас жилийн байдлаар айл өрхүүд дунджаар 14.3 сая төгрөгийн зээл авсан байна. Өрхийн зээлийн 37 хувийг цалингийн зээл, 25 хувийг хэрэглээний зээл, 21 хувийг тэтгэврийн зээл, 14 хувийг ипотекийн зээл, 32 хувийг бусад зээл бүрдүүлж байна.
- Төрийн албан хаагчдын цалин, тэтгэврийн нэмэгдэл, ногдол ашиг олголт зэргээс хэрэглээний зээл өмнөх оны мөн үеэс 62.1 хувиар буюу 483,000 төгрөгөөс 782,000 төгрөг болж нэмэгдсэн байна.
- Ипотекийн зээлийн төлбөр 700,000 төгрөгөөс 1,027,000 төгрөг болж 46.7 хувиар, өмнөх оны мөн үеэс орон сууцны үнийн дундаж өсөлт 12.8 хувиар өссөн байна. Хуучин орон сууцны үнэ мкв нь 3.40 сая төгрөгөөс 3.96 сая төгрөг болж 14.5 хувиар, шинэ орон сууцны үнэ мкв нь 3.69 сая төгрөгөөс 4.11 сая төгрөг болж 10.8 хувиар өсжээ.

МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕЭС 9.8 ИХ НАЯД ТӨГРӨГӨӨР НЭМЭГДЭЖ, 41.8 ИХ НАЯД ТӨГРӨГТ ХҮРЛЭЭ.

- Төгрөгийн хадгаламж өмнөх оны мөн үеэс 38.4 хувиар өсөж, 20 их наяд төгрөгт хүрсэн ба 17.2 их наяд төгрөг нь иргэд, 2.8 их наяд төгрөг нь байгууллагын хадгаламжаас бүрдэж байна. Нөгөөтээгүүр валютын хадгаламж 8 хувиар буурч, 4.5 их наяд төгрөг болсон байна.
- Төгрөгийн харилцах данс өмнөх оны мөн үеэс 54.5 хувиар өсөж 11.1 их наяд төгрөгт хүрсэн бол гадаад валютын харилцах данс 11.1 хувиар өсөж 5.1 их наяд төгрөгт хүрсэн байна.
- Валютын нөөц өмнөх оныхоос 23.8 хувиар өссөн ч, өнгөрсөн сарынхаас 2.1 хувиар буурч 4,737 сая ам.доллар болсон.
- Төлбөрийн тэнцэл оны эхний хагаст 57.3 сая ам.долларын алдагдалтай гарсан нь импорт нэмэгдэж, гадаад худалдааны тэнцэл 22.3 хувиар буурч, урсгал дансны алдагдал нэмэгдсэнтэй холбоотой.


ХУРААНГУЙ

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	НЭГЖ	ТАЙЛАНТ ХУГАЦАА	ӨМНӨХ ҮЕ	ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕ	ЖИЛИЙН ӨСӨЛТ
УЛИРЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2024Q2	2024Q1	2023Q2	
Бодит ДНБ	тэрбум төгрөг	14,407	6,065	13,631	5.7%
Ажилгүйдлийн түвшин	%	5.76%	5.11%	5.76%	0.0%
САРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2024M07	2024M06	2023M07	
Гадаад худалдааны үзүүлэлтүүд					
Нийт экспорт	сая ам доллар	9,327	7,947	8,699	7.2%
Зэс	сая ам доллар	1,747	1,454	1,548	12.9%
Нүүрс	сая ам доллар	5,361	4,675	4,960	8.1%
Нийт импорт	сая ам доллар	-6,411	-5,378	-5,024	27.6%
Хэрэглээ	сая ам доллар	-1,852	-1,522	-1,461	26.7%
Түүхий эд	сая ам доллар	-549	-466	-474	15.8%
Хөрөнгө оруулалт	сая ам доллар	-2,747	-2,322	-2,022	35.9%
Шатахуун	сая ам доллар	-1,253	-1,060	-1,059	18.3%
Тэнцэл	сая ам доллар	2,916	2,569	3,675	-20.7%
Дэлхийн түүхий эдийн үнэ					
Зэс	\$/тонн	9,385	9,648	8,477	10.7%
Нүүрс	\$/тонн	142	144	141	0.7%
Газрын тос	\$/баррель	84	83	80	4.9%
Алт	\$/трой унц	2,394	2,328	1,950	22.8%
Улсын нэгдсэн төсөв					
Төсвийн тэнцэл	тэрбум төгрөг	1,373	1,101	1,360	0.9%
Төсвийн орлого	тэрбум төгрөг	16,634	14,012	12,439	33.7%
Төсвийн зардал	тэрбум төгрөг	-15,262	-12,911	-11,079	37.8%

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	НЭГЖ	ТАЙЛАНТ ХУГАЦАА	ӨМНӨХ ҮЕ	ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕ	ЖИЛИЙН ӨСӨЛТ
САРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2024M07	2024M06	2023M07	
Мөнгөний бодлого					
М2 нийлүүлэлт	тэрбум төгрөг	41,754	41,467	32,021	30.4%
ХҮИ (C2015)	индекс	145.5	145.4	138.0	5.5%
Бодлогын хүү	%	11.0%	11.0%	13.0%	-15.4%
Хүү ба ханш					
Ам долларын ханш (Эцсийн)	Төгрөг/\$	3,381	3,381	3,455	-2.1%
Төгрөгийн хадгаламж	%	11.3%	11.6%	11.0%	2.9%
Валютын хадгаламж	%	3.9%	2.9%	3.5%	12.2%
Төгрөгийн зээл	%	16.8%	17.1%	16.3%	3.1%
Валютын зээл	%	10.7%	11.0%	11.0%	-3.1%
Гадаад валютын нөөц					
Нийт	сая ам доллар	4,737	4,839	3,827	23.8%
Үнэт цаас	сая ам доллар	2,455	2,615	1,689	45.4%
Харилцах, хадгаламж	сая ам доллар	1,617	1,531	1,620	-0.2%
ОУВС-д байршуулсан хөрөнгө	сая ам доллар	7	7	7	-1.7%
Зээлжих тусгай эрх	сая ам доллар	97	96	115	-15.4%
Мөнгөжсөн алт	сая ам доллар	560	590	396	41.4%

БОДИТ ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

■ Бодит ДНБ-ны өсөлт (C2015)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

АЖИЛГҮЙДЭЛ БА ЦАЛИН




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ




Эх сурвалж: Монголбанк

ДЭЛХИЙН ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ



Эх сурвалж: ОУВС

УЛСЫН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

УЛСЫН ГАДААД ӨР




Эх сурвалж: Монголбанк

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ




Эх сурвалж: Монголбанк

УЛСЫН ИНФЛЯЦИ




Эх сурвалж: Монголбанк

ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ



Эх сурвалж: Монголбанк

АМ ДОЛЛАРЫН ХАНШ



Эх сурвалж: Монголбанк

БАНКУУДЫН ДУНДАЖ ХҮҮ



Эх сурвалж: Монголбанк



АНХААРУУЛГА

Голомт банкны Эдийн засгийн судалгааны алба нь Монгол улсын макро эдийн засгийг бүхэлд нь хамарч судалдаг билээ. Энэхүү тайлан нь макро эдийн засгийн хамгийн сүүлийн үеийн өгөгдлийг ашигласан болно. Энэхүү тайланд тусгагдсан агуулга, санаа нь Голомт банкны байр суурийг илэрхийлэх албагүй болно. Голомт банкнаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр энэ тайлангийн аль нэг хэсгийг хуулбарлах, системд хадгалах, ямар нэг хэлбэрээр дамжуулах, цахим механик хэлбэрээр хувилах, бичлэг хийхийг хориглоно.

ЕРӨНХИЙ ЭДИЙН ЗАСАГЧ

Ө. Мөрөн

Цахим хаяг: murun_u@golombank.com

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЭЭЧ

Б. Анунжин

Цахим хаяг: anunjin.ba@golombank.com

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЭЭЧ

Б. Дархлан

Цахим хаяг: darkhlan@golombank.com

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЭЭЧ

С. Цацрал

Цахим хаяг: tsatsral.sa@golombank.com

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЭЭЧ

О. Номуншүр

Цахим хаяг: nomushur@golombank.com